



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/485

Булган сум

Агентлаг, байгууллагын дарга нарын
2024 оны хагас жилийн Гүйцэтгэлийн
төлөвлөгөөг дүгнэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагын 2024 оны эхний хагас жилийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Төрийн албан хаагчийн Гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн холбогдох журмын дагуу урамшуулал олгохыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010655

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 сарын 01-ны өдрийн А/495 тоот
Захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг,
байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн
Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

| Д/д | Агентлаг, байгууллагуудын нэр | Үнэлгээ хувиар |
|-----|--|----------------|
| 1 | Аймгийн Засаг даргын тамгын газар | 91.2 |
| 2 | Онцгой байдлын газар | 93.4 |
| 3 | Цагдаагийн газар | 93.5 |
| 4 | Шүүх шинжилгээний хэлтэс | 94.3 |
| 5 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар | 95.2 |
| 6 | Улсын бүртгэлийн хэлтэс | 82.3 |
| 7 | Санхүүгийн хяналт дотоод аудитын алба | 90.8 |
| 8 | Татварын хэлтэс | 93.97 |
| 9 | Орон нутгийн өмчийн газар | 90.7 |
| 10 | Худалдан авах ажиллагааны газар | 88.6 |
| 11 | Боловсрол шинжлэх ухааны газар | 94.4 |
| 12 | Эрүүл мэндийн газар | 90.0 |
| 13 | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар | 80.3 |
| 14 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар | 90.3 |
| 15 | Нийгмийн даатгалын хэлтэс | 99.7 |
| 16 | Биеийн тамир, спортын газар | 94.5 |
| 17 | Хүнс хөдөө аж ахуйн газар | 88.9 |
| 18 | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 70.2 |
| 19 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 92.0 |
| 20 | Мал эмнэлгийн газар | 86.0 |
| 21 | Статистикийн хэлтэс | 93.7 |
| 22 | Стандартчилал хэмжил зүйн хэлтэс | 88.8 |
| 23 | Соёл урлагийн газар | 89.0 |
| 24 | Эрүүл мэндийн даатгалын хэлтэс | 86.5 |
| 25 | Музей | 80.0 |
| 26 | Хөгжимт жүжгийн театр | 76.3 |
| 27 | Аймгийн Төв номын сан | 86.4 |